

Гэмт хэргийг мэдэгдэх арга

- **Гэмт хэргийн үйл явдлыг харах, эсвэл хохирогч болох зэрэг тохиолдолд та 112 дугаар луу залгаснаар цагдаагийн газраас хурдан түргэн тусламж авах боломжтой.**
 - ▶ Цагдаад мэдэгдэхдээ тухайн байршил нөхцөл байдлыг мэдэгдэж хэзээ-хаан а-яаж ямар байдлаар хохирол амссан эсэх, гэмт хэрэгтний дүр төрх, онцлог, биед нь байсан эд онцлох эд зүйл, хүний тоо, явсан зүг чиг, ямар зам тээвр ийн хэрэгслээр явсан гэх зэргийг нарийн мэдэгдэх хэрэгтэй.
 - ▶ **112 дугаарт мэдэгдэхэд гар утас (видео дуудлага боломжтой)** , энгийн утас, таксфон зэргээр холбогдох боломжтой бөгөөд таксоны тохиолдолд яаралтай үед дуудлага хийх тохиолдолд **(Улаан өнгийн яаралтай дуудлага хийх товчлуурыг +112) зоосгүй** байсан ч дуудлага өгөх боломжтой ба өөр яаралтай үед ч ашиглах боломжтой
 - ※ **Гадаад хүн 112 дугаар луу дуудлага өгөх тохиолдолд гурвалсан орчуулга (Цагдаа-орчуулагч-дуудлага өгөгч) гэсэн үйлчилгээ байгаа бөгөөд гэмт хэрэг(хохирол)-н дуудлага хийх боломжтой.**
 - ▶ Дуудлага хийх боломжгүй үед '112 Emergency Reporting App' гэсэн утасны апп байх бөгөөд мөн мессежээр дуудлага хийх боломжтой.
 - ※ **'112 Emergency Reporting App' утсандас Google Play Store мөн Apple App Store-оос татаж авна уу.**
 - ▶ Гэмт хэргийн газарт цагдаа нар үзлэг хийж нотлох баримт, гэмт хэргийн дүн шинжилгээ хийх шаардлагатай тул хэргийн газарт гар хүрэлгүй ул мөрийг хадгалж өгнө үү.

Яаралтай тусламжийн дугаарын жагсаалт

Гэмт хэргийн дуудлага болон яаралтай дуудлага	
Гэмт хэргийн дуудлага (Цагдаагийн газар)	112
Сургуулийн орчин дахь хүчирхийлэл (Цагдаагийн газар)	117
Гал түймэр-яаралтай өвчтөн-яаралтай аврах анги (Гал команд)	119
Хакер-scam- хувийн мэдээлэл алдагдах (KISA)	118
Эмэгтэйчүүдийн яаралтай тусламжийн дуудлага (Эмэгтэйчүүд гэр бүлийн яам)	1366
Danuri дуудлагын төв (Эмэгтэйчүүд гэр бүлийн яам)	1577-1366
Бусад дуудлага	
Гадаад иргэдийн нэгдсэн төв (Хууль зүйн яам)	1345
Төрийн байгууллагын санал гомдол (Захиргааны аюулгүй байдлын газар)	110
Гадаад иргэдийн аялал жуулчлалын нэгдсэн танилцуулга(КТО)	1330
Хүний эрхийн эрх зүйн зөвлөгөө (Төрийн хүний эрхийн холбоо)	1331
Хууль зүйн зөвлөгөө (БНСУ хууль зүйн байгууллага)	132
Хүүхдийн эрхийн мэргэжлийн байгууллага (Нийгмийн халамжийн яам)	129
Өсвөр насны кибер зөвлөгөө (Эмэгтэйчүүд гэр бүлийн яам)	1388

Солонгос улсад амьдарч буй гадаад иргэдэд зориулсан тусламж

- **Цагдаагийн байгууллага нь хууль зүйн яамтай хамтран гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлэх мөн гадаад ирэгдийн эрхийг хамгаалах үүднээс “Хууль бус гадаад иргэдийг мэдээлэхээс чөлөөлөх” гэсэн тогтолцоог явуулж байна.**
 - ▶ «Хууль бус гадаад иргэдийг мэдээлэхээс чөлөөлөх» гэдэг нь хууль бус иргэн гэмт хэргийн хохирогч болсноо цагдаагийн байгууллагад мэдэгдэхэд тухайн гадааад иргэний хувийн мэдээллийг тухайн орон нутгийн цагаач иргэн харъяатын газар мэдээлэхгүй байх тогтолцоо юм.
 - ▶ Холбогдох гэмт хэргийн төрөл нь дараах болно.

【Эрүүгийн гэмт хэрэг】

Хүн амьны гэмт хэрэг, гэмтэл-хүчирхийлэл, санамсаргүй хүний аминд хүрэх,хайхарч хандалгүй орхих, хүчирхийлэл, баривчлах-хорих, сүрдүүлэг, урхихдах, бэлгийн хүчирхийлэл-хүчин, эрхээ эдлэхэд саад болох, хулгай дээрэм, луйвар, заналхийлэл

【Тусгай хуулийн гэмт хэрэг】

Хүчирхийлэл зэргийн ял шийтгэлтэй холбоотой хууль, бэлгийн хүчирхийллийн тусгай хууль, зам тээврийн ослын тусгай хууль, ажлын байрны аюулгүй байдлын хууль (46дугаар зүйл)

*Гэмт хэргийн хохирогч болсон тохиолдолд эргэлзэлгүй 112 дугаарт дуу длага өгөн тусламж авахыг зөвлөж байна.

- **Цагдаагийн газар биечилж ирэхгүй байсан ч гэмт хэргийн (хохирол) дуудлага болон санал гомдлоо өгч болохоор гадаад иргэд чөлөөтэй ханддаг “олон соёлт гэр бүлийг дэмжих төв”-NGO байгууллагыг“гадаад иргэдэд туслах төв” болгон ажиллуулж байна.**

★ Арга заавар

1. Гадаад иргэн гэмт хэргийн хохирогч (хүсэлт) болох
2. Гадаад иргэдэд туслах төвд хандах-зөвлөгөө авах
3. Гадаад иргэдийг хариуцсан цагдаад бүртгүүлэх-зөвлөгөө авах
4. Цагдаагийн газар болон холбогдох байгууллагад хандах хэргийг шийдвэрлэх



- ▶ Гадаад иргэнд туслах төвд биечлэн очиж гэмт хэргийн хохирлыг мэдэгдэх эсвэл өөрт хэрэгтэй тусламж дэмжлэг хүсэх үед тус байгууллага гадаад иргэдийг хариуцсан цагдаад мэдэгдэн таны мэдэгдсэн мэдээлэл болон авсан зөвлөгөөний агуулгыг цааш дамжуулж өгч, цагдаагийн хэлтэс хэргийг шийдвэрлэхэд туслах бөгөөд шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагад хандана.

★Гэмт хэргийн дуудлага болон зөвлөгөөний агуулгатай холбоотой арга хэмжээ

- Хүчирхийлэл-гэр бүлийн хүчирхийлэл-сургуулийн хүчирхийлэл-залилан (мэдэгдэх-яллах) зэрэг эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой хэргийг цагдаагийн газар шийдвэрлэнэ.
- Цалин хөлс хойшлуулах-үйлдвэрийн осол-оршин суух визний ангилал з эрэгтэй холбоотой зүйлийг хөдөлмөрийн яам, эмэгтэйчүүд гэр бүлийн яам, хууль зүйн яам гэх газрууд руу шилжих ба санал хүсэлтээс хамаараад эл чин сайдын болон консулын хэлтэс рүү холбогдоно.

※ Гадаад иргэдэд туслах төвийг өөрт ойр цагдаагийн газрын гадаад иргэдийг хар иуцсан хэлтсээс лавлаж мэднэ үү.

- **Гэмт хэргээс (хохирол) урьдчилан сэргийлэх сургалт мөн жолооны эрхийн сургалт авах боломжтой.**
 - ▶ Гадаад иргэд нийгэмд тогтвортой суурьшихийн төлөө
 - Олон соёлт гэр бүлийн дэмжих төв, ажлын байр, NGO зэрэг гадаад хүмүүс ихээр төвлөрсөн газарт биеэр очиж, гэрлэлтийн цагаач, хөдөлмөр эрхлэгч гадаад иргэн, гадаад оюутан зэрэг хүмүүст зориулсан тохиолдож болзошгүй гэмт хэргийн төрөл зүйл, анхаарах хэрэгтэй зүйл зэргийг нарийн танилцуулж хэцүү зүйлд нь зөвлөгөө өгөх 'гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт' -ыг зохион байгуулж байна
 - Мэргэжлийн багштай гадаад хүмүүст зориулсан жолооны эрхийн сургалтын ангийг ажиллуулж байна. (Гурван хэлээр хэвлэгдсэн сургалтын номтой.)

- ★ **Жолооны эрхийн шалгалттай холбоотой лавлах бол**
 - Зам тээврийн байгууллага жолооны эрхийн шалгалтын газар: 1577-1120 (www.safedriving.or.kr)
 - Шалгалт : 3 хэлээр (Англи хэл, хятад хэл, вьетнам хэл) шалгалт өгөх боломж той.

※ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт болон жолооны эрхийн сургалтыг өөрт ойр байрлах цагдаагийн газрын гадаад иргэдийг хариуцсан хэлтсээс лавлана уу.

- **Солонгос хэл мэдэхгүй хүмүүст зориулан гэмт хэрэг мэдэгдэх, зөвлөгөө авах үед гадаад хэлний орчуулгын үйлчилгээ үзүүлж байна.**

Орчуулгын байгууллага	Нарийн агуулга
Аялал жуулчлалын орчуулга (1330)	· Төв байгууллага: КТО · Ажиллах цагийн хуваарь: Гурвалсан орчуулга боломжтой (Англий хэл/хятад хэл/япон хэл 24 цаг) Бусад 5 хэл 08-19 цагийн хооронд болом жтой. (365 өдөр) · Хэл: Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Малайз, Индонез (8 төрлийн хэл)
Danuri call center (1577-1366)	· Төв байгууллага: Эмэгтэйчүүд гэр бүлийн яам · Ажиллах цагийн хуваарь: Гурвалсан орчуулга боломжтой. /Англи хэл, Хятад хэл, Вьетнам хэл, Филиппин хэл 24цаг боломжтой/ Бусад 9 хэл 08-21цаг (365 өдөр) · Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Монгол, Филиппин, Кампуж, Узбекистан, Лаус, Непаль (12хэл)
Гадаад иргэдийн нэгдсэн төв (1345)	· Төв байгууллага: хууль зүйн яам, Гадаад иргэн харъяатын газар · Ажиллах цаг: Гурвалсан орчуулга боломжтой. / Англи хэл, Хятад хэл 09~ 22 цаг / Бусад 17 хэл 09~ 18 цаг (Ажлын өдөр) · Англи, Хятад, Япон, Орос, Вьетнам, Тайланд, Индонез, Монгол, Филиппин, Камбуж, Араб,Непаль, Франц,Испани, Мьянмар, Бангладеш, Шри-ланка,Пакистан, Герман (19 хэл)
BBB Korea (1588-5644)	·Төв байгууллага: Ашгийн бус байгууллага (Иргэний) · Ажиллах цаг: гурвалсан орчуулга боломжтой. (Апп) / 24цаг (365 өдөр) ·Хэл: Англи, Хятад,Япон,Орос, Вьетнам, Тайланд, Малайз, Индонез, Монгол, Араб, Франц, Испани, Португаль, Швед,Польш,Итали, Герман, Турк, Энэтхэг,Свахили (20 хэл)



Гадаад иргэдэд зориулсан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гарын авлага



Мэдэхгүйгээс үүдэн амархан үйлдэгддэг гэмт хэрэг

- **Хүчирхийлэл, гэмтэл, айлган сүрдүүлэх, гэрт нь халдах, эд хөрөнгөд хохирол учруулах, цагдан хорих, албадлага хийх, сүрдүүлэх гэх мэт гэмт хэргийн зорилгоор бүлэглэл үүсгэсэн тохиолдолд хүнд шийтгэл хүлээнэ**
- **Хүний амь нас, бие махбодид ноцтой хохирол учруулах хутга, төмөр саваа, төмөр хөрөө гэх мэт хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хор хөнөөл учруулж болзошгүй зэвсэг авч явах ёсгүй**
- **Та мөнгөөр мөрийтэй тоглох ёсгүй, мөрийтэй тоглоом тоглох газар өгсөн ч мөрийтэй тоглоомын дагуу хатуу шийтгэл хүлээх болно.**
- **Хэрэв та зам дээр тавьсан унадаг дугуй зэрэг хараа хяналтгүй мэт санагдах зүйлийг авбал хулгайлах, завшсан хэргээр шийтгэгдэж болзошгүй.**
- **Санхүүгийн байгууллагаар дамжихгүйгээр хувийн гүйлгээгээр гадаад руу мөнгө гуйвуулсан бол хатуу шийтгэл оногдуулдаг.**
- **Мансууруулах бодис үйлдвэрлэх, хууль бусаар хил нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх тохиолдолд хүнд шийтгэл хүлээх ба энэ тохиолдолд албадан хүчээр гаргах болно.**
 - Цагдаагийн ерөнхий байгууллага нь ▲хар тамхи хууль бусаар ханган нийлүүлсэн гэмт хэрэгтнүүд ▲гадаадын хар тамхины гэмт хэрэгтнүүд ▲Интернэт (хар вэб) болон SNS ашиглан хар тамхины гэмт хэрэгтнүүдийн эсрэг эрчимтэй тэмцэж байна.
- **17-оос дээш насны гадаадын иргэд паспорт эсвэл гадаадын иргэний үнэмлэхээ үргэлж биедээ авч явах ёстой, зөрчсөн тохиолдолд торгууль (1 сая-с доош) ноогдуулна.**
 - Хэрэв та хэн нэгний үнэмлэх ашигласан эсвэл өөрийн хувийн мэдээллийг хуурамчаар үйлдэхийг оролдвол, хууран мэхлэх замаар албан үүргээ гүйцэтгэхэд саад учруулсан хэргээр шийтгэгдэж болзошгүй.
- **Хууль бус зураг авалт, бэлгийн чиг хандлагатай бичлэг зэргийг дамжуулах нь хүнд шийтгэл хүлээгдэнэ.**
 - Биеийн харилцаа холбоогүй байсан ч ①Интернэт, гар утсаар бэлгийн дур хүслээр гутаасан, жигшин зөвүүцсэн үг, зураг дамжуулах ②Бусдын биеийг зөвшөөрөлгүйгээр авах, тараах ③Хууль бусаар дүрс бичлэг хийсэн материалыг эзэмших, худалдан авах, хадгалах, үзэх нь гэмт хэрэг болно.



- **Автомашин, мотоцикль, цахилгаан скутер жолоодоход дараах үед хатуу шийтгэл оногдуулна.**
 - Хэрэв та жолооны үнэмлэхгүй автомашин, мотоцикль, цахилгаан скутер жолоодсон бол шийтгэл хүлээх болно.
 - Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон тохиолдолд шийтгэл хүлээх болно.
 - Хэрэв та хуулийн дагуу шилжүүлэгдээгүй машин жолоодвол шийтгэл хүлээх болно. (гэрчилгээгүй машин)



- **ндсэн дэг журмыг зөрчсөн тохиолдолд ч торгууль ногдуулдаг гэдгийг анхаарах хэрэгтэй.**
 - Тамхины иш, бохь, хогоо хамаагүй хаяж болохгүй.
 - Олон нийтийн газар шүлсээ хаях, тамхи татах хориотой бүс газарт тамхи татаж болохгүй.
 - Мотоцикль болон цахилгаан скутер унах тохиолдолд хамгаалалтын малгай өмсөх ёстой
 - Цахилгаан скутерийн хувьд хоёроос дээш хүн унах ёсгүй
 - Зам хөндлөн гарахдаа гүүрэн гарц эсвэл явган хүний гарцаар (ногоон гэрэл) хөндлөн гарах ёстой.



Өдөр тутмын амьдралдаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зөвлөмжүүд

- **Залилан (хууль бус сүлжээний бизнес, утасны санхүүгийн луйвар, smishing, интернетийн луйвар гэх мэт)**
 - Хууль бус сүлжээ: Ерөнхий бөөний/жижиглэнгийн түгээлтийн үе шатыг дамжихгүйгээр бүтээгдэхүүнийг хэрэглэгч шууд борлуулах тохиолдолд, дараах тохиолдолд компанид гишүүнээр элсэх эсвэл худалдагчаар элсэх урилгаас татгалзана уу
 - Богино хугацаанд өндөр ашиг олох өгөөш болгон гишүүн, хөрөнгө оруулагч элсүүлж, хуримтлал үүсгэх, албадан худалдан авах, зээл олгох гэх мэт.
 - Цагийн ажил, гэрээсээ хийх боломжтой ажил, ажилд орох зэргээр өгөөш тавин борлуулагчаар элсүүлэн бодит байдал дээр хүчээр бүтээгдэхүүн худалдан авалт хийлгэх тохиолдолд
 - Чанартай бараа бүтээгдэхүүн мэтээр худал, хэтрүүлсэн сурталчилгаа хийж өндөр үнээр борлуулах үед
- ★ **Бүртгэгдсэн хууль ёсны компани мөн эсэхийг шалгах лавлагаа** ☎☎
 - Шударга Худалдааны Комисс www.ftc.go.kr, 1670-0007 (төлбөртэй)
 - Шууд борлуулалтын харилцан туслах нийгэмлэг www.macco.or.kr, 02-566-1202
 - Солонгосын тусгай борлуулалтын харилцан туслах нийгэмлэг www.kossa.or.kr, 02-2058-0831~8
- Утсаар санхүүгийн залилан үйлдэх: Утсаар төрийн байгууллага, санхүүгийн байгууллагын дүр эсгэж данс, карт, оршин суугчийн регистрийн дугаар гэх мэт данс шилжүүлэх, бэлэн мөнгө шилжүүлэх хүсэлт, хувийн мэдээлэл зэрэг өөрийн мэдээллийг шаардсан тохиолдолд хариу өгөхгүй байх.
- ※ **Луйврын бүлэглэлийн доор бэлэн мөнгө гаргах, утсаа ашиглуулах зэрэг мөн адил луйврын гэмт хэрэгт хамрагдах бөгөөд хүнд ял шийтгэл авна.**
- ★ **Voice Phishing хохирлын кейс**
 - Гэр бүл (хүүхэд) утсаар ярих боломжгүй нөхцөлийг үүсгэн хулгайлсан гэж хууран мөнгө нэхэх
 - Прокурор, цагдаа гэх мэт мөрдөн байцаалтын байгууллагын дүр эсгэж, гэмт хэрэгт холбогдсон, хувийн мэдээлэл задруулсан нэрийдлээр мөнгө нэхэх.
 - Санхүүгийн байгууллагын дүр эсгэж, урьд авсан зээл, шимтгэл, төлбөрөө төлөх нэрээр мөнгө нэхэх.
 - Зээлийн картын компани юм уу харилцаа холбооны компани гэж нэрлэж, төлбөрөө хэтрүүлсэн нэрийн дор мөнгө нэхэх
- Smishing: Хэрэглэгчдийг санхүүгийн мэдээллээс урьдчилан сэргийлэхийн тулд хортой програм суулгахад өдөөх зорилгоор хортой програмын хаягийг агуулсан гар утасны мессеж илгээх. ойр дотны хүн илгээсэн байсан ч орохын өмнө дахин нягтлан утасныхаа хамгаалалтыг сайжруулж урьдчилан сэргийлэх хэрэгтэй.
- Интернет залилан: Интернетээр хувь хүмүүсийн хооронд гүйлгээ хийхдээ гүйлгээ хийхээсээ өмнө аюулгүй гүйлгээний сайт ашиглах эсвэл хүлээн авагч талын мэдээллийг (утасны дугаар, дансны дугаар) шалгах ёстой.

- ※ Та цагдаагийн газар (www.police.go.kr) эсвэл Cybercop (мобайл апп)-аар дамжуулан интернэт залилан мэхэлсэн түүхийг хайж, хохирлын талаар мэдээлэх боломжтой.
- **Гэр бүлийн хүчирхийлэл-Болзооны хүчирхийлэл**
 - Гэр бүлийн хүчирхийлэл-Болзооны хүчирхийлэл үүссэн тохиолдолд, эргэлзэлгүй тэр дор нь цагдаа , хамаатан садан, хөрш, найз нөхөддөө өөрийн нөхцөл байдлын талаар мэдэгдэж тусалцаа хүсэх шаардлагатай.
 - ※ **Зураг-Эмчийн бичиг зэрэг хүчирхийлэлд өртсөнийг гэрчлэх баримтийг бүрдүүлэх, Эмэгтэйчүүдийн нийгэмлэг-тусламжийн байгууллага зэрэгт хандан мэргэжлийн зөвлөгөө авах (Эмэгтэйчүүдэд зориулсан яаралтай тусламж, зөвлөгөө авах утас 1366 / Danuri Call Center1 1577-1366)**
- **Хүүхэд алга болох, Хүүхдийн хулгай**
 - Бага насны хүүхдэрүү танихгүй хүн ойртон таньдаг царайлан авч явах эсвэл хүчээр дагуулан авч явахыг оролдох тохиолдолд чангаар орилон эргэн тойрноосоо тусламж хүсэх хэрэгтэй талаар зааж сургах
 - Хүүхдэд өөрийн овог нэр-нас-гэрийн хаяг-утасны дугаар- эцэг эхийн нэр зэргийг хэлж сурган гадагшаа гарсан тохиолдолд хэнтэй хаашаа явсан, ямар хувцас өмссөн зэргийг санан тогтоох
- **Сургуулийн орчин дахь хүчирхийлэл**
 - Сургуулийн орчин дахь хүчирхийлэл гэдэг нь сургуулийн дотор болон гадна орчинд сурагчийн биед халдах, дарамтлах, гадуурхах зэрэг үүнээс үүдэн бие мах бодийн болон сэтгэл санааны-хөрөнгө мөнгөний хохирол учруулах зэргийг хэлнэ. Хэрэв ийм хохирол дарамтад өртсөн тохиолдолд тэр дор нь хариуцсан багш, эцэг эх, цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ үү.
 - Хүний хөдөлгөөн багатай нарийн гудам, аюултай зам зэргээр аль болох явахгүй байх, бүлэглэн халдлагад өртөн үнэт эдлэл зэргээ дээрэмдүүлсэн тохиолдолд заавал цагдаад мэдэгдэнэ үү.
- **Бэлгийн гэмт хэрэг (хүчиндэх/хүчээр дарамтлах, хууль бус зураг авалт, дижитал секс гэмт хэрэг гэх мэт)**
 - Хэрэв та бэлгийн хүчирхийлэлд өртсөн бол 112 дугаарт яаралтай мэдэгдэнэ үү. (Цагдаад мэдэгдэхээс өмнө усанд оролгүй өмсөж байсан дотуур хувцас зэргийг тэр хэвээр нь хадгалснаар гэмт хэрэгтнийг илрүүлэхэд тус болно)
 - Гэмт этгээдийн онцлог, гадаад төрх зэрэг нөхцөл байдлын талаар санаж байгаа бүх зүйлээ бичнэ үү
 - Таны эргэн тойронд бэлгийн гэмт хэргийн хохирогч болсон хүмүүс байвал 1577-1366 дугаарын утсанд хандаж, зөвлөгөө тусламж авахад туслаарай.
- **Хулгай (хоосон гэрт орж дээрэм хийх, халаасны хулгай, булаах гэх мэт)**
 - Хэрэв та гэрээсээ удаан хугацаагаар гадуур явах, амралт зугаалгаар явах гэх мэт удаан хугацаагаар эзэнгүй байх тохиолдолд хүргэлтийн зүйлээ гэрийн үүдэнд их хэмжээгээр удаан бөөгнөрөхгүйн тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, үнэт эдлэл, бэлэн мөнгө зэрэг үнэт зүйлсээ банкинд хадгалах нь эрсдэлгүй.
 - Олон хүн цуглардаг терминал, автобус буудал, зах гэх мэт хөл хөдөлгөөн ихтэй газруудад анхаарал сарнисан завсарыг ашиглан эд зүйлсийг авч зугтаж болзошгүй тул болгоомжтой байх хэрэгтэй.
 - Санхүүгийн байгууллагаас их хэмжээний бэлэн мөнгө авахдаа хамгаалалтын цагдаа эсвэл цагдаагийн албан хаагчаас тусламж хүснэ үү
- ※ **Цагдаагийн ерөнхий газраас гаргасан хохирогчийг дэмжих мэдээллийн хэрэгтүүр болох "PoCare App"-г Google Play Store эсвэл Apple App Store-оос та тааж авсны дараа ашиглах боломжтой.**